

## **ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 04

Өлгий хот

Ээлжит хурлыг 13.00 цагаас компанийн хурлын танхимд хуралдуулж хурлыг дарга А.Манен удирдав.

Хуралд нийт 536177 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааны 421148 ширхэг буюу 78.6 хувийг эзэмшигч Д.Мурат, 75800 ширхэг буюу 14.13 хувийг эзэмшигч М.Тилеуберди нар болон компанийн ТУЗ-ийн дарга А.Манен, гишүүд А.Бейбит, У.Харашаш, Ц.Баттөмөр, Х.Адалбек, хараат бус гишүүд А.Мубарак Х.Ертай, Е.Жанболат, санхүүгийн ажилтнууд оролцов.

Хурлын тооллогын комиссын мэдээллийг комиссын дарга О.Адилбект анилцуулав./Мэдээллийг хавсаргав./

Хуралд компанийн дүрмийн 7.4 дэх хэсэгт заасны дагуу нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 92.73 хувь нь оролцож байгаа тул хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэв.

### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Компанийн 2021 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах
3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

**А.Манен:** Компанийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар хурлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж эхний асуудал болох Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг хэлэлцэе. Холбогдох хүмүүс танилцуулга хийе.

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн гишүүн А.Бейбит танилцуулав. /2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хавсаргав./ Дараа нь хуралд оролцогчид саналаа хэлэв.

**Д.Мурат:** Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлттэй танилцлаа. Санхүүгийн тайлангийн аудитыг Санхүүгийн зохицуулах /хороонд бүртгэлтэй аудитын компаниар хийлгэж баталгаажуулсан байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа компаниар хийлгэсэн нь дэвшилттэй зүйл болсон байна. Компанийн санхүүгийн тайлангаас үзэхэд авах авлага нилээн байгаа юм байна. Энэ нь ямар учиртай вэ?

**Ерөнхий нягтлан бодогч К.Ерболат:** 2020-2021 оны халаалтын улиралд манай аймагт 8 сараар халаалт өгөх Эрчим хүчний сайдын тушаал гарсан. Энэ тушаалын дагуу төсөвт байгууллагуудтай 8 сараар гэрээ хийсэн боловч ихэнх төсөв байгууллагуудын халаалтын зардал төсөвт 7-7.5 сараар сууж ирсэн байдаг. Ихэнх

байгууллагуудын төсөв 0,5-1 сараар дутуу ирсэн.Үүнээс болж ихээхэн хэмжээний авлага үүсч байна.

**Д.Мурат:** Компанийн хувьд 2021 оны үйл ажиллагааг шаардлагын хэмжээнд сайн гүйцэтгэж явуулсан байна. ТУЗ-ийн дүгнэлтийг дэмжиж байна.

**А.Бейбит:** Манай компанийн хувьд 100 хувь хувийн өмчийн компани гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа.Улс, орон нутгийн зүгээс ямар нэгэн санхүүгийн дэмжлэг, татаас байхгүй.Өнгөрсөн зун дулаан дамжуулах шугамуудыг өргөтгөх, нэг зуухыг иж бүрэн засварлах зэрэг ажлуудыг өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийж дулаан дамжуулах хүчин чадлыг нэмэгдүүлсэн..Тооцооны инженерийг шинээр томилж Улаанбаатар хот руу сургалтанд явуулж дадлага сургуулилт хийлгэсэн. Эдгээр ажлуудыг хийхэд нилээд хөрөнгө зарцуулсан.Бүх ажлыг өөрийн хөрөнгөөр хийх боломжгүй учир банкнаас зээл авч гүйцэтгэсэн. Үүнээс шалтгаалан компанийн ашиг бага гарч байгаа тал бий.2021 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдсан.

**М.Тилеуберди:** Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлттэй бүрэн танилцсан. Дүгнэлт үндэслэлтэй зөв хийгдсэн байна. Өнгөрсөн онд хийсэн засвар, шинэчлэлийн талаар ТУЗ-ийн гишүүн А.Бейбит тодорхой ярилаа. Төсөвт байгууллагуудын халаалтын хөлс төсөвт бүрэн суугаагүйгээс ихээхэн өр авлага үүсч байна. ТУЗ-ийн дүгнэлтийг дэмжиж байна.Хуралд оролцогчдоос өөр санал гаргасан хүнгүй. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар нууцаар санал хурааж саналыг тоолоход саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжсэн. Дараа нь ТУЗ-ийн дарга А.Манен хурлаас гаргах тогтоолын төслийг танилцуулж саналтай хувьцаа эзэмшигч байгаа эсэхийг тодруулахад төсөлтэй холбоотой санал гаргаагүй. Тогтоолын төслийг батлах асуудлаар илээр санал хураахад хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжив.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** 1.Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг санал нэгтэй батлах.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**2.Компанийн 2021 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн хараат бус аудиторын тайланг танилцуулах

**А.Манен:** Одоо аудитын тайлангийн талаар хэлэлцье. Энэ талаар ерөнхий Нягтлан бодогч К.Ерболат танилцуулья. К.Ерболат компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн Аккурэйт аудит ХХК-ийн аудитын тайланг уншиж танилцуулав./Аудитын тайланг хавсаргав./

**Д.Мурат:**Аудитын тайлантай танилцлаа.Бодит дүгнэлт хийсэн байна.Аудит хийсэн компаниас орлого, үр дүнгийн тайланд удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагааны зардлыг ерөнхий ба удирдлагын зардалд тусгаж жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулган дэлгэрэнгүй тусгаж харуулах нь зүйтэй гэсэн. зөвлөмж өгсөн байна. Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж дараагийн жил ийм асуудал гаргахгүй байх хэрэгтэй.Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт үүрэг болгоё.

**К.Ерболат:**Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно. Хуралд оролцогчдоос өөр санал гаргасан хувьцаа эзэмшигчгүй. Хэлэлцэж байгаа асуудлын талаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар нууцаар санал хурааж саналыг тоолоход саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжсэн байна.Дараа нь ТУЗ-ийн дарга А.Манен хурлаас гаргах тогтоолын төслийг танилцуулж саналтай хувьцаа эзэмшигч байгаа эсэхийг тодруулахад төсөлтэй холбоотой санал гаргаагүй. Тогтоолын төслийг батлах асуудлаар илээр санал хураахад хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжив.

**А.Манен:**Компанийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр хурлаар ногдол ашиг хувиарлах эсэх асуудлыг хэлэлцэн ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн.Хуульд зааснаар энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэх ёстой.Энэ талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Адалбек танилцуулья.

**О.Адалбек:** Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д зааснаар ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хувиарлах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байх ёстой. Энэ асуудлыг компанийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцээд ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн. Учир нь компанийн 2021 оны ЖИЛИЙН ЭЦСИЙН тайлангаар 34.590.700 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч нийт өглөг 5.195.485.100 төгрөгт, авлага 1.293.945.800 төгрөгт хүрч ногдол ашиг хувиарлах тухай Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан шаардлагыг хангахгүй байна. Энэ нь компанийн цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулахад ихээхэн хүндрэл учруулж байгаа тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн.

**А.Манен:**ТУЗ-ийн шийдвэрийн талаарх ТУЗ-ийн мэдээллийг сонслоо. Зөв шийдвэр гаргасан байна.Дэмжиж байна.

**А.Бейбит:**Би ТУЗ-ийн хуралд оролцон энэ асуудлыг хэлэлцэхэд танилцуулга хийж байсан. Ямар нэгэн санал байхгүй. Хэлэлцсэн асуудлаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар нууцаар санал хурааж саналыг тоолоход саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжсэн байна. Дараа нь ТУЗ-ийн дарга А.Манен хурлаас гаргах тогтоолын төслийг танилцуулж саналтай хувьцаа эзэмшигч байгаа эсэхийг тодруулахад төсөлтэй холбоотой санал гаргаагүй. Тогтоолын төслийг батлах асуудлаар илээр санал хураахад хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжив.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** 1.Ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг санал нэгтэй дэмжиж батлах

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:** 3.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

А.Манен: Надад нэг санал байна. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох саналтай байна.Та бүхэн ямар бодолтой байна.ТУЗ-ийн одоогийн гишүүдийг дурьдвал даргаар нь би, гишүүдээр А.Бейбит, У.Харашаш, Ц.Баттөмөр, О.Адалбек, харин хараат бус гишүүд нь А.Мубарак,Х.Ертай,Е.Жанболат нар юм. Эдгээрийг улиран сонгох саналтай байна.

**М.Тилеуберди:** Би ТУЗ-ийн даргатай санал нэг байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

Гишүүдээс өөр санал гаргасан хүнгүй. ТУЗ-ын даргын оруулсан санлын дагуу ТУЗ – ийн гишүүдийг улиран сонгох санал 100% - тар нэгтэй дэмжигдэв.

Хурлыг 16.45 цагт дуусгав.

**Тэмдэглэл хөтөлсөн:** ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

О.Адалбек

**Танилцсан:** Хурлын дарга

А.Манен



**ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ**

2022.04.28

Тус компани нь Баян-Өлгий аймгийн төв бүх айл өрх, албан байгууллагуудад дулааны эрчим хүч үйлдвэрлэж түгээдэг.

2021 онд 105 хүний бүрэлдэхүүнтэйгээр эрчим хүчний зохицуулах хорооноос авсан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Тус компаниас худалдан борлуулах дулааны эрчим хүчний үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооноос 2021 оны 10 сарын 14 өдрийн 466 тоот тогтоолын дагуу мөрдөж ажиллаж байна.

Дээрх тогтоолын хавсралтад зааснаар дулааныг нэмэгдсэн өртгийн албан татваргүйгээр албан байгууллагуудад 1600, орон сууцанд амьдардаг айл өрхүүдэд 800 төгрөг, ААНэгжүүд 1200 төгрөгөөр борлуулж байна.

Тус бүр 13Гкал/цаг – ийн хүчин чадалтай KE25-14 маркийн 3 зуух болон 20 Гкал/цаг - ийн хүчин чадалтай KBTC-20-150 маркийн 1 зуухтайгаар ажиллаж байна. KE25-14 нэг зуухыг тоног төхөөрөмжийг шинэчилж 2021 оны 01 сард ашиглалтанд оруулав. Үлдсэн 3 зуухаар өлгийн горим ажиллагааг хэвийн хангав.

Нийт 1761 хэрэглэгчээс айл өрх 1321, хувийн амины орон сууц 211, төсөвт байгууллага 48, аж ахуйн нэгж 181 байна.

Тайлант хугацаанд 34,5090,650.83 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч 1,098,505,021.71 төгрөгийн дансны өглөгтэй, татварын албанд төлөх 570,459,829.35 төгрөгийн, НДШ-ийн өглөг 18,874,778.96 төгрөг, банкнаас авсан богино хугацааны зээл 7,420,209.67 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, урт хугацаат зээл 3,477,987.862.95 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө 6,937,714,730.69 биет бус хөрөнгө 107,719,560 эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн 7,045,434,290.69 нийт хөрөнгийн дүн 9.502,482,316.56 төгрөг байна.

Мөнгөн зарлагын дүн 4,975,172,798.57 төгрөг байгаагаас ажилчидад олгосон мөнгөн зарлага 759,575,090 нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө 177,171,596 бараа материал худалдан авахад төлсөн мөнгө 360,511,551 ашиглалтын зардалд төлсөн мөнгө 302,276,075 түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн үнэд 1,727,825,083.5 хүүд төлсөн 642,430,780.4 татварын байгууллагад 189,164,289.1 төгрөг, даатгалын төлбөрт 4,335,532.2 төгрөг тус тус төлсөн байна.

Компанийн 2021 оны санхүүгийн тайланг 2021 оны 12 сарын 31 – ний өдрөөр тасалбар болгон гаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Аккурэйт аудит” ХХК – иар аудит хийлгэсэн болно.

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Аккурэйт аудит” ХХК -иар хийлгэж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажилласан байна гэж компанийн ТУЗ дүгнэж байна.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.МАНЕН

**“ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН МЭДЭЭЛЭЛ**

2022.04.28

Өлгий сум

“Эрчимбаян өлгий” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон тооллогын комисс нь тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн мэдээг гаргаж нэгтгэлээ.

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 536177 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигч оролцох ёстойгоос 421148 ширхэг буюу 78.6 хувийг эзэмшигч Д.Мурат, 75800 ширхэг буюу 14.13 хувийг эзэмшигч М.Тилеуберди нар ирсэн байна. Дээрх хоёр хувьцаа эзэмшигч нийтдээ 496948 ширхэг энгийн хувьцаа буюу нийт хувьцааны 92.73 хувийг эзэмшиж байгаа бөгөөд өөрсдөө хуралд биечлэн хүрэлцэн учир хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг хангалттай гэж тооллогын комисс үзэж хурлын даргад мэдээлж байна.
2. Саналын хуудасны загварыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер,дилерийн компаниудад урьдчилан хүргүүлсэн ба хувьцаа эзэмшигч нараас саналаа урьдчилан ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй байна.
3. Хэлэлцэж байгаа 3 асуудлаар зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн томъёоллоор санал өгнө. Хурлаас гарах шийдвэрийг хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар батална гэдгийг тайлбар болгож байна.

Засварласан, балласан болон залруулгатай санал авах хуудас нь хучингүйд тооцогдоно гэдгийг анхаарна уу. Хурлын ажиллагаанд амжилт хүсье.

“ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ” ХК-ийн  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



О.АДИЛБЕК

“Эрчимбаян өлгий” ХК-ийн ТУЗ-ийн  
2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн  
02 дугаар тогтоолоор батлав

**“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
САНАЛ АВАХ ХУУДАС**

Компанийн оноосон нэр: “Эрчимбаян өлгий” ХК

Хурал хуралдах газар, өдөр, цаг: 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13:00 цагаас  
компанийн хурлын зааланд хуралдав.

Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр: Мурат Тилеуберди

Эзэмшлийн хувьцааны төрөл, тоо: 75800

**А.Ердийн аргаар санал авах асуудал**

| д/д | Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн товч утга                                                      | Дэмжсэн<br>/+/ | Татгалзсан<br>/+/ | Түдгэлзсэн<br>/+/ |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------|----------------|-------------------|-------------------|
| 1   | Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах |                |                   |                   |
| 2   | Компанийн 2021 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах; |                |                   |                   |
| 3   | Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох                                                     |                |                   |                   |

Санал авах хуудас үйлдсэн... оны 04 сарын... өдөр

Саналын хуудсыг тоолж хүчинтэйд тооцож тоолсон

Тооллогын комиссын дарга... О.Адилбек

Гишүүд: Ш. Майраш

Ж. Серикжан

**ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД  
КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 67.2-Д ЗААСАН  
ШААРДЛАГЫГ ХАНГАСАН ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2021.04.28

| д/д | Тооллогын<br>комиссын<br>гишүүдийн нэр | Албан тушаал             | Компанийн<br>хувьцаа<br>эзэмшдэг<br>эсэх | Компанийн<br>эрх бүхий<br>албан<br>тушаалтан<br>эсэх | Нэгдмэл<br>сонирхолтой<br>эсэх |
|-----|----------------------------------------|--------------------------|------------------------------------------|------------------------------------------------------|--------------------------------|
| 1   | О.Адилбек                              | Борлуулалтын<br>байцаагч | үгүй                                     | үгүй                                                 | үгүй                           |
| 2   | Ш. Майраш                              | Бичиг хэргийн<br>ажилтан | үгүй                                     | үгүй                                                 | үгүй                           |
| 3   | Ж. Сериюжан                            | ХАБЭА инженер            | үгүй                                     | үгүй                                                 | үгүй                           |

БОЛОВСРУУЛСАН:ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТАНИЛЦСАН:ТУЗ-ИЙН ДАРГА



О.АДАЛБЕК

А.МАНЕН